

УЛС ТӨРИЙН МАНИПУЛЯЦИ БА ОЛОН НИЙТИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА

Д.ДОЛГОРСҮРЭН

Докторант, МУИС, ШУС-ийн ахлах багш,

Түлхүүр үгс: Улс төрийн манипуляци, олон нийтийн дипломат ажиллагаа, олон улсын харилцаа

Товч утга: Дипломат ажиллагааны нэг хэлбэр болох Олон нийтийн дипломат ажиллагааг улс төрийн манипуляцтай адилтгаж үзэх хандлага судлаачдын дунд ажиглагдаж байна. Улс төр судлалын нэгэн чиглэл болсон манипуляцийн үзэгдлийг судалж, олон нийтийн дипломат ажиллагаатай харьцуулж, улмаар энэ хоёр ойлголтыг ялгах зорилгоор энэхүү судалгааны өгүүллийг бичлээ.

Abstract: This article refers to the difference between political manipulation and public diplomacy. The political manipulation is the major problem of research of sociopolitical sciences which is still insufficiently studied in the scientific literature. Naturally, in one article it is impossible to capture all aspects of both political manipulation and public diplomacy; therefore I would like to consider their concepts and definitions by comparing them with one another.

XX зуун гарсаар дэлхий ертөнц ихэд өөрчлөгдөж, хүн төрөлхтөний нийтлэг эрх ашгийг хөндсөн бэрхшээлтэй асуудлууд олширч, дэлхийн хэмжээнд интеграцийн үйл явц эрчимжиж, улс гүрнүүдийн харилцан шүтэлцээ, бие биеэс хамаарах хамаарал нь улам гүнзгийрч байна. Ийм нөхцөлд дэлхийн улс төр, олон улсын харилцаанд гадаад бодлогын идэвхтэй үйл ажиллагаа нэн шаардлагатай болж байна. Олон улсын харилцаанд гарч буй өөрчлөлттэй уялдан улс гүрнүүд олон улсын тавцан дээрх хамтын үйл ажиллагааны идэвхтэй оролцож, гадаад бодлогоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд иргэд, олон нийтийн оролцоо, нөлөөг дэмжиж идэвхжүүлэх нь ихээхэн ач холбогдолтойг ухаарч байгаа нь дэлхий нийтийн улс төр, дипломат ажиллагааны арга барил, хэв маягт үлэмж нөлөө үзүүлэх болжээ.

Улс орнуудын тоо нэмэгдэж, хаант улс эрс цөөрч, улс нийгмийн болоод олон улсын харилцааны өөрчлөлтөөс шалтгаалан дипломат ажиллагаа хувьсан өөрчлөгдөж, түүнийг хэрэгжүүлэх үйл явц, хэлбэр, зохион байгуулалт, нууцлал, олон нийтэд ил байх зарчим, хэрэгжүүлэх арга барилын тухай асуудалд улс гүрнүүд өөр өөрийн өнцгөөс янз бүрээр хандаж ирлээ. Орчин цагийн дипломат ажиллагаа зөвхөн улс төрийн харилцааг энхийн замаар хөгжүүлэхэд чиглэгдээд зогсохгүй эдийн засаг, нийгэм, олон нийтийн харилцааг хөгжүүлэхэд түлхүү чиглэж, өргөн цар хүрээг хамрах болжээ.

Улс төрийн шинжлэх ухааны нэг том дэд салбар гэж тооцогддог ч сүүлийн үед бие даасан шинжлэх ухаан хэмээн судлаачдын үзэх болсон¹ дипломат ажиллагаа нь эртнээс улбаатай, мэргэжлийн суурь боловсрол, практик туршлага, харилцах ур чадвар, ёс зүй зэрэг нарийн цогц ажиллагаа, эв дүй шаардсан, улам бүр хөгжиж буй шинжлэх ухааны чухал судлагдахууны нэгд тооцогдох боллоо. Тийм учраас "Дипломат ажиллагаа бол улс хоорондын харилцаанд хүч хэрэглэхээс урьдчилэн сэргийлэх зорилгоор соёл иргэншлийн зохион бүтээсэн хамгийн шилдэг зүйл мөн" хэмээн Францын дипломат, улс төрч А. Брогли хэлжээ. Английн нэрт дипломат судлаач Эрнест Сатов "Guide to the diplomatic practice"² хэмээх бүтээлдээ "Дипломат ажиллагаа бол шинжлэх ухаан мөн"³ гэж нотлон бичжээ. Мөн Оросын нэрт дипломат, эрдэмтэн В. И. Попов "Дипломат ажиллагаа бол шинжлэх ухаан, ур чадвар мөн"⁴ гэжээ.

Аливаа улсын явуулж буй дипломат үйл ажиллагаа нь тухайн улсын нэрийн хуудас болдог учраас дипломат ажиллагаа нэн чухал бөгөөд олон хэлбэртэй байдаг. Дипломат ажиллагааны хамгийн гол хоёр хэлбэрийг:

- Уламжлалт дипломат ажиллагаа⁴
- Шинэ буюу орчин үеийн дипломат ажиллагаа⁵ гэж нэрлэдэг.

Дипломат ажиллагааг ерөнхийд нь хоёр талт болон олон талт гэж ангилдаг. Хоёр талт гэдэг нь уламжлалт буюу хуучны дипломат ажиллагаа бөгөөд "францын", "италийн" дипломат ажиллагаа гэж нэрлэгддэг⁶. Шинэ буюу орчин үеийн дипломат ажиллагааг олон талт дипломат ажиллагаа гэж нэрлэдэг бөгөөд түүний илрэх нэг хэлбэр нь олон нийтийн дипломат ажиллагаа юм.⁷ Шинэ дипломат ажиллагааны

¹ Францын судлаач Франсуа Кальер, английн судлаач Эрнест Сатов, Shaun Riordan, Jan Melissen, Nicolas Cull, Оросын судлаач В. И. Попов зэрэг олон эрдэмтдийг дурьдаж болно.

² Ernest Satow, "Guide to diplomatic practice", 5th ed. London, New York, 1979

³ В. И. Попов, "Орчин үеийн дипломат ажиллагаа" (Онол практикийн асуудал), Улаанбаатар, 2007.

⁴ (Traditional diplomacy) хоёр талт гэж нэрлэдэг

⁵ (New diplomacy) олон талт дипломат ажиллагаа гэгддэг

⁶ Peu Ghosh, "International relations", New Delhi-110001, 2009; p. 107

⁷ Ibid., p. 108-113

гол онцлог нь олон нийтэд нээлттэй, ил явагддаг ба мэдээлэл харилцаа, техник технологийн дэвшлийн нөлөөгөөр мэргэжлийн дипломатын үүрэг ролийг багасгаж, улмаар гадаад бодлогын хэрэгжилтэд нөлөөлөх олон нийтийн оролцоо, иргэний нийгэм, хүн хоорондын харилцааг чухалчилж нээлттэй болгосон явдал юм. Тийм учраас *"1918 оноос хойших олон улсын харилцаанд гарсан их өөрчлөлтөөс үүдэн дипломат ажиллагааны алтан үе эхэлсэн"* гэж үздэг.

Дипломат ажиллагааны уламжлалт хэв маяг, арга хэлбэр өөрчлөгдөж, орчин үеийн дэлхий ертөнцийн нөхцөл байдлаас шалтгаалан олон янзын шинэ хэлбэр, төрхтэй болж байгаа хэдий ч улс орнуудын засгийн газар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх, бэхжүүлэх: үзэл бодол, мэдээллийг дамжуулах: байр сууриа харилцан илэрхийлэх: үндэсний язгуур эрх ашиг, сонирхлоо хамгаалах: улс бүр бусдаас ялгаатай өөрийн гадаад дотоод бодлого, эрх ашгаа хэлэлцэн зохицуулах зэрэг дипломат ажиллагааны яриа хэлэлцээний үндсэн үүрэг зорилго нь өөрчлөгдөөгүй хэвээрээ гэж үзэж болно.

Олон улсын харилцаа үлэмж өргөжиж буй өнөө үед олон улсын аливаа чухал асуудлыг шийдвэрлэхэд дэлхийн ихэнх орнууд оролцох шаардлагатай болж байна. Тэдний үзэл санааг нэгтгэж, нэг тохиролцоонд хүргэх нь нэн хүнд, цаг хугацаа шаардсан хэрэг юм. Их гүрнүүд болон хөгжиж буй улсууд бусад орнуудад нөлөөгөө бэхжүүлэхийн тулд гадаад бодлогод улс төрийн манипуляци хийж явдал түгээмэл болжээ. Үүний зэрэгцээ олон нийтийн дипломат ажиллагааг ч эрчимтэй явуулах болжээ. Тэгэхдээ улс төрийн манипуляцыг дипломат ажиллагаатай, тэр дундаа олон нийтийн дипломат ажиллагаатай адилтгаж үзэх нь бий. Гэтэл энэ хоёр нь шинж чанар, нэр томъёоны хувьд ч өөр өөр ойлголт юм.

Улс төрийн манипуляци (political manipulation) гэдгийг улс төр судлалд хүмүүсийн улс төрийн ухамсар үйл байдлыг өөрийн эрх ашгийн үүднээс далд аргаар удирдах явдал гэж тодорхойлдог. Манипуляци нь аливаа нөхцөл байдлыг давуу тал болгон эргүүлэх, ялангуяа өөрт ашигтай байдал руу илүү хандуулах зорилготой үйлдэл бол дипломат ажиллагаа нь ерөнхийдөө нэгэн цагт явцуу хүрээнд нууц явагддаг байсан ч Дэлхийн I дайнаас хойш нээлттэй ил болж, харилцан ашигтай байдлыг чухалчилдаг, хуулийн дагуу явагддаг үйл ажиллагаа юм.⁸ Манипуляци нь улс төр судлал, олон нийтийн санаа бодлын социологи, улс төрийн сэтгэл зүй зэрэг шинжлэх ухааны салбаруудын аль алины судалгаанд хамрагддаг өргөн хүрээтэй асуудал боловч нийгмийн шинжлэх ухааны салбарууд дахь харьцангуй бага судлагдсан ухагдахуунд тооцогддог. Улс төрийн манипуляцийг эдгээр салбарууд олон янзаар тайлбарладаг. Тухайлбал:

- Хүмүүсийг удирдах, нөлөөлөх зорилготой, тэднийг далд аргаар албаддаг улс төрийн үйл ажиллагаа / далд нөлөөлөх хэлбэрээр явагддаг /
- Хүмүүсийг төөрөгдүүлэх зорилгоор сэтгэл зүйд нь нууцаар нөлөөлөх үйл явц
- Хүмүүсийг тодорхой үйлдэл хийлгэх, эсвэл үл хийлгэх зорилготой өнгөлөн далдалсан арга хэрэгсэл гэх мэт

Улс төрийн манипуляци болон олон нийтийн дипломат ажиллагаа хоёрын гол ялгаа юу вэ? Хэдийгээр энэ хоёр ойлголтыг нэг л өгүүлэлд бүрэн тайлбарлах боломжгүй ч юуны өмнө дипломат ажиллагаа гэдгийг товч тайлбарлаж, шинэ дипломат ажиллагааны хамгийн оновчтой хэлбэр гэж өдгөө зүй ёсоор тооцогдож буй олон нийтийн дипломат ажиллагааг улс төрийн манипуляцитай харьцуулахыг оролдоё.

Олон улсын хэмжээний эдрээтэй, чухал асуудлуудыг шийдвэрлэх үйл ажиллагаа нь мэргэжилтэн шинжээчдийн, сайд нарын, өндөр дээд хэмжээний, олон улсын байгууллагын гэх мэт хэд хэдэн түвшинд явагдах болсноос үүдэн улс төр, олон улсын харилцаа, дипломат ажиллагаа улам бүр нарийсч, ихээхэн хүч хөрөнгө шаардах болжээ⁹. XVIII, XIX зуунд дипломат ажиллагаа нь цэрэг, улс төрийн харилцаа руу голлон чиглэж байсан бол XX зуунаас худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёл, олон нийт, хуучин үнэмлэхүй харилцаа руу чиглэх болжээ¹⁰. Ерөнхийдөө нийгмийн болон олон улсын харилцаан дахь өөрчлөлтөө шалтгаалан дипломат ажиллагаа хувьсан өөрчлөгдөх шинжтэй байдлыг бүр XVIII зуунд Франсуа Кальер онцлон тэмдэглэж байжээ.¹¹ "Дипломат ажиллагаа" гэдэг үгийг Францад 1716 оноос, Их Британид 1780-аад оны сүүлээс, Орост 1790-ээд оноос хэрэглэх болсон бөгөөд энэ нэр томъёог Франсуа Кальер¹² анх хэрэглэж, 1716 онд бичсэн "Улс орнуудтай хэлэлцээ явуулах арга" бүтээлдээ оруулжээ. Тэрээр дипломат ажиллагааны гол зүйл нь яриа хэлэлцээ гэж үздэг байв.

⁸ Peu Ghosh, "International relations", New Delhi-110001, 2009, p. 107

⁹ The Concise Oxford Dictionary of Politics, NY, 2009, p. 328

¹⁰ В. И. Попов, "Орчин үеийн дипломат ажиллагаа" (Онол практикийн асуудал), Улаанбаатар, 2007.

¹¹ Д. Цолмон, Д. Оюу ноёрэн, С. Баясгалан, "Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс", УБ, 2009, х. 28-30

¹² В. И. Попов, "Орчин үеийн дипломат ажиллагаа" (Онол практикийн асуудал), УБ, 2007, х. 55

¹³ Европын хэд хэдэн оронд Людовик XIV хааны элчин сайдаар томилогдон ажиллаж, чухал ач холбогдол бүхий олон яриа хэлэлцээрт амжилттай оролцож явсан Францын дипломат судлаач Кальерийн дээрх ном өнөө үед ч ач холбогдлоо алдаагүй байгаа төдийгүй мэргэжлийн дипломатчдыг бэлтгэн гаргадаг өрнө, дорнын их дээд сургуулиудад заавал судлах сурах бичиг болгон ашиглагддаг.

Улс гүрнүүд өөр хоорондоо харилцах гол арга болсон дипломат ажиллагааг аливаа зөрчилдөөн, буруу ойлголцоол, сөргөлдөөний байдлаас зайлсхийж, бусад улс орнуудтай харилцах харилцаагаа аль болох сайнаар хадгалахын тулд хэлэлцэн тохиролцох урлаг гэж хэлж болно. Учир нь аливаа дипломат ажиллагаа гэдэг нь энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах таатай суурь нөхцөл, гадаад бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхэд чиглэсэн, өргөн хүрээтэй үйл ажиллагаа билээ. Энэхүү цогц ойлголт нь олон хэлбэрээр илэрдэг бөгөөд түүний нэг хэлбэр нь олон нийтийн дипломат ажиллагаа юм.

Аливаа улс бусад гүрэнтэй харилцахдаа ард иргэдээр нь дамжуулан хоорондын харилцаагаа ойртуулж, харилцан ойлголцоол, итгэлцлийг бий болгох замаар гадаад бодлогын таатай орчинг бүрдүүлэх зорилготой дипломат ажиллагааны нэг хэлбэрийг олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг. Өөрөөр хэлбэл, төр засгаас явуулж буй гадаад орнуудын талаарх бодлогыг боловруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нийгэм дэх ашиг сонирхлын бүлэглэлүүд, төрийн бус байгууллагууд, олон нийтийн оролцоо, нөлөө бүхий иргэд, хүн хоорондын харилцааг ашиглах, тэдэнтэй хамтран ажиллах замаар улсынхаа гадаад бодлогыг бусад улс гүрний ард иргэдэд ойлгуулж, эерэг зөв сэтгэгдэл төрүүлснээр засгийн газарт нь нөлөөлж, хоорондын харилцаа хамтын ажиллагаандаа нааштай уур амьсгалыг бий болгох зорилготой дипломат ажиллагааг олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг.

АНУ-ын судлаач Николас Калл "Олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг нь олон улсын байдлыг олон нийтийн оролцоотойгоор зохицуулах гэсэн оролдлого юм"¹⁴ гэжээ. Түүний бичсэнээр олон нийтийн дипломат ажиллагаа нь гадаадын олон нийтэд шууд нөлөөлөх хэлбэрээр явагддаг бөгөөд тэднийг анхааралтай сонсож, хандлага, арга замыг нь аажмаар өөрчлөх, ингэснээр үр дүнд нь хамгийн гол бодлогыг нь өөрсдийн бодсончлон зөв байлгах явдал ажээ. Тэрээр "Public Diplomacy: Lessons from the Past" буюу "Олон нийтийн дипломат ажиллагаа: Өнгөрсөн үеэс авах сургаж" нэртэй бүтээлдээ Тухайн улсын хувьд гадаад бодлогынхоо чухал элемент гэж үзэж байгаа аливаа асуудлыг нь анхаарч дэмжих зэргээр олон нийттэй холбоотой ажилладаг дипломат ажиллагаа бол Олон нийтийн дипломат ажиллагаа юм,¹⁵ гэж дүгнэжээ. Олон нийтийн дипломат ажиллагаа нь нэг улсын засгийн газар ба нөгөө улсын ард иргэдийн хооронд харилцаа холбоо тогтоох хэлбэрээр явагдаж иржээ. Тэгэхдээ, шууд олон нийт масс руу чиглэлгүй, харин өргөн хүрээнд нөлөөлж чадах тодорхой хэсэг бүлэг рүү, хувь хүн рүү чиглэсэн үйл ажиллагааг голлон явуулж ирсэн юм. Өөрөөр хэлбэл, засгийн газруудаар бус харин ард иргэдээр нь дамжуулан улс орнуудтай харилцахыг чухалчилдаг, улс орноо сайнаар таниулан сурталчлах зорилгоор явуулж буй дипломат ажиллагааг олон нийтийн дипломат ажиллагаа гэж үзэж болно.

Дэлхийн улс төр, олон улсын харилцаанд хүн хоорондын харилцаа улам өсөн нэмэгдэж, олон нийтийн үүрэг оролцоо ихэсч, бодлого боловруулагчдын шийдвэрт нөлөөлөх болжээ. Ялангуяа олон улсын харилцааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр улс төрчид, засгийн эрх баригчид хуран цуглаж, хуралдан мэтгэлцэж байдаг ч зөвшилцөлд хүрэх, буулт хийх улстөрчийн чадвар дутагдах нь түгээмэл билээ. Ийм үед олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлэх буюу харилцан зөвшилцсөн, олон талт хувилбарыг олон нийтийн өргөн оролцоотойгоор хэлэлцэн шийдвэрлэж байх нь илүү үр өгөөжтэй болж байна. Даяаршлаас үүдэн улс орнуудын дотоод гадаад бодлогын ялгаа улам багасч байна.

Олон нийтийн дипломат ажиллагаа нь иргэд, олон нийтийн дэмжлэгтэйгээр улс орнуудын засгийн газар хоорондын харилцааг ойртуулж, харилцан ойлголцоол, итгэлцлийг бий болгож, гадаад бодлогын таатай орчинг бүрдүүлэх зорилготой байдаг. Олон нийт буюу хүмүүсийг улс төрийн үйл явцын гурав дахь оролцогч гэдэг. Улс төрийн хүчнүүд засгийн эрхийг гартаа авах, эрх мэдлээ тогтоон барьж, улс төрийн дотоод, гадаад зорилгоо ханган биелүүлдэхийн тулд олон түмний тус дэмжлэгийг зайлшгүй авах шаардлагатай байдаг. Тийм учраас улс төр, олон нийт, хэвлэл мэдээлэл гэсэн гурван субъектыг улс төрийн алтан гурвалжин гэж улс төрийн шинжлэх ухаанд нэрлэдэг. Олон нийтээр дамжин хэрэгжих учиртай олон нийтийн дипломат ажиллагаа нь харилцан ойлголцоол, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих, гадаадын олон нийтийн сонирхлыг татсан институт, үйл ажиллагааны тусламжтайгаар өөрийн орны нэр хүндийг өргөх, ингэснээр бусад улстай улс төр эдийн засгийн хүрээнд хэлхээ холбоо тогтоож, үр ашгийг нь хүртэх зорилготой дипломат ажиллагаа юм. Олон улсын хэмжээнд үнэн зөв мэдээлэл дамжуулж, улс орныхоо талаар эерэг ойлголт, дүр төрх бий болгох нь олон нийтийн дипломат ажиллагааны үндсэн зорилт учраас харь улс оронд гадаад бодлогоо явуулах засгийн газрын таатай хөрс суурь нь чухам энэ дипломат ажиллагаа болдог.

¹⁴ Nicholas J. Cull, "Public Diplomacy: Lessons from the Past", Los Angeles, 2009.

¹⁵ Ibid.,

Олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрдэг

- Уламжлалт дипломат ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн тэлэх,
- Гадаад бодлогын таатай орчныг бүрдүүлэх

• Олон нийтийн болон төрийн бус байгууллагууд, нийгмийн доторх ашиг сонирхлын бүлэглэлүүдийн үзэл баримтлал, үүрэг нөлөөг дээшлүүлэх юм.¹⁶

Олон нийтийн дипломат ажиллагааг явуулахын гол зорилго нь зөвхөн засгийн газар хооронд явагддаг улс төрийн яриа хэлэлцээг цөөлж, олон нийтэд ил тод үйл ажиллагаа явуулж, нийгэмд нөлөөлөх явдал байдаг. Нэг улсын засгийн газар нөгөө улсынхаа засгийн газрын шийдвэрт нөлөөлөхийн тулд ард түмнийх нь санаа бодолд, мөн тухайн улсын талаарх дэлхий нийтийн санаа бодолд ерөнхийд нь нөлөөлөх зорилгоор явуулж буй дипломат үйл ажиллагааг олон нийтийн дипломат ажиллагаа гэж үздэг. Улс төрчид, засгийн газруудаар бус харин ард иргэдээр нь дамжуулан харилцахыг чухалчилдаг энэ дипломат ажиллагааг улс төр, эдийн засаг, соёлын гэх мэт дипломат ажиллагааны бусад хэлбэрүүдтэй хослуулан явуулах нь ихээхэн ач холбогдолтой байдаг.

Олон түмний санаа бодолд нөлөөлж, тэдний үзэл бодол, сэтгэгдлийг тусгасны үндсэн дээр хэрэгждэг Олон нийтийн дипломат ажиллагааны гол онцлог нь:

1. Олон нийтэд нээлттэй, шууд явагддаг
2. Гадаад бодлого, дипломат ажиллагааны талаар иргэдийг мэдээллээр хангадаг. олон нийтийн саналыг бодлого боловсруулахдаа харгалзан үзэж, үр дүнг тооцдог, төрийн бодлогын дотоод механизмын үүргийг гүйцэтгэдэг
3. Гадаад бодлогыг хэрэгжүүлэх, сурталчлах, таниулах арга хэрэгсэл болдог.

Олон нийтийн дипломат ажиллагаа нь улс төрийн манипуляци биш, пропаганда ч биш, Улс төрийн манипуляци гэж олон түмнийг төөрөгдүүлэх, худлаа хоосон амлах, далд нөлөөлөх, хуурамч уриа лоозон хэрэглэж, богино хугацаанд олон түмний дунд нэр нөлөөтэй болохыг эрмэлздэг популистүүдийн үйл ажиллагааг хэлдэг. Харин олон нийтийн дипломат ажиллагаа нь нийгэм дэх нөлөө бүхий иргэдийн мэдлэг туршлагаар дамжуулан бусад сайнаар нөлөөлж, улс төрийн болоод гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад хүмүүсийг үр дүнтэй оролцохыг ил дэмжиж, үнэн бодитой мэдээллээр шуурхай хангахыг эрмэлздэг дипломат ажиллагаа юм.

Улс төрийн манипуляци нь олон түмнийг идэвхгүй бөгөөд мэдээллээр дутмаг байлгаж, бие биеэ даган дуурайсан, хийрхсэн, бодит байдлыг гуйвуулсан үйл ажиллагаа байдаг бөгөөд гол зорилго нь олон түмний итгэл үнэмшилд нөлөөлөх явдал байдаг. Олон нийтийн дипломат ажиллагаа ба улс төрийн манипуляци хоёрын олон түмний итгэл үнэмшилд нөлөөлөх гэсэн зорилго нь ижил, хоёулаа нэг зүг чигт, нэг үр дүнг чухалчилж байгаа боловч улс төрийн манипуляцийг явуулахдаа сэтгэл зүйн дарамт шахалт үзүүлж, мэдээллийн их урсгалаар бөмбөгддөг. Тэгэхдээ ач холбогдол багатай мэдээллийг нь голлон дамжуулж, өнгөлөн далдлалт хийж, гол асуудлаас анхаарлыг холдуулах үүднээс мэдээлэл тараадаг. Улс төрийн шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь бичигт манипуляцыг нөхцөл байдлыг өөрт ашигтай тал руу эргүүлэх, ялангуяа гол асуудлын хэлэлцэх дэс дарааг өөрчлөх, (хэрэв санал хураалт явуулж буй бол давуу саналтай яваа талыг унагах зорилгоор журмыг өөрчлөх), өөрсдөдөө ашигтай шинэ санал оруулах зэрэг арга хэрэгсэл ашиглан өөрчлөлт хувиргалт хийх гэсэн утгатай хэмээн тайлбарлажээ.¹⁷

Олон нийтийн дипломат ажиллагаа нь мөн нөлөөлөх үйл ажиллагаа боловч энэхүү дипломат ажиллагааг хэрэгжүүлсний үр дүн нь урт настай, удаан хугацаанд үргэлжилдэг бөгөөд сайн үр дүнд хүргэдэг. Жишээлбэл эрдэмтэд солилцооны хөтөлбөрүүд, боловсролын солилцоо нь олон нийтийн дипломат ажиллагааны нэг идрэл юм. Улс төрийн манипуляци нь уран үг, харагдах байдлыг чухалчилдаг бол олон нийтийн дипломат ажиллагаа нь сайн үр дүн, жинхэнэ мэдлэг туршлага, халуун дотно харилцааг бий болгодог. Үг яриа, уран илтгэл зэрэг нь оюун санаагаар үйл явдлын учир шалтгааныг ухааран ойлгох явдлыг бүрхэгдүүлж байдаг. Улс төрийн манипуляцыг уран үгийн мастер болсон популистууд хэрэглэх нь их бөгөөд тэдний тоо олшрох нь улс орны хөгжилд ихэнхдээ сөрөг нөлөө үзүүлдэг. Популистууд зөрчил мөргөлдөөн, үндэс угсаа, зэрэг зиндаа, шашин шүтлэгийн ялгааг зориуд дэвэргэж, нийгмийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, улс төрийн хямралд хүргэдэг. Олон нийтийн санаа бодлыг өөрчлөн улс төрийн манипуляци хийх явдал тоталитар, авторитар дэглэмтэй улсуудад түгээмэл төдийгүй ардчилсан улс орнуудад ч сонгуулийн үед манипуляцыг их хэрэглэдэг.

Олон нийтийн дипломат ажиллагаанд үйлдлийг, үйлсийг голлодог. Зүгээр ярих биш хийх, түр зуурын биш, урт хугацааны үр ашигтай харилцаа холбоог дээд албаныхны дунд бус олон түмний дунд бий болгохыг эрхэмлэдэг. Тийм учраас бүх нийтээр хүсэн тэмүүлдэг үнэт зүйлс, чиг зорилгыг

¹⁶ Д. Цолмон, Д. Оюунсүрэн, С. Баясгалан, "Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс", УБ, 2009, х.41

¹⁷ The Concise Oxford Dictionary of Politics, New York, 2009, p.238

үл хэрэгсэгч завсрын бүлэг болох маргиналь давхаргынхны тоо улам цөөрч, хүн төрөлхтөний хүсэн тэмүүлдэг жинхэнэ ардчилал, үнэт зүйл бэхжиж, нийгмийн хямрал хөгжил дэвшлээр, амар тайвнаар солигдон тогтворжсоноор дэлхийн улс төрийн байдалд ч эерэгээр нөлөөлөх боломжтой гэж үздэг олон нийтийн дипломатууд нь популистуудаас үзэл бодлын хувьд эрс ялгаатай байдаг.

Олон нийтийн дипломат ажиллагааны гол үүрэг нь олон нийтийн санаа бодол, хүсэл хандлагад нөлөөлөх замаар шийдвэр гаргагчдал хүрч, тэдний үйл ажиллагаагаар дамжуулан улс орнуудын хооронд харилцаа тогтоох, улс орны иргэд хоорондын ойлголцлыг бэхжүүлэх, өөрийн гадаад бодлогын ашиг сонирхлыг бусад улсад хүлээн зөвшөөрүүлэх таагай нөхцлийг бүрдүүлэх, олон талт харилцааг хөгжүүлэх зэрэг улс төр, эдийн засаг, соёлын болоод бусад дипломат ажиллагааг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох явдал юм.

Дэлхийн улс гүрнүүдийн хүчний харьцаа, нөлөө бүхий томоохон гүрнүүдийн байр суурьтай уялдан, түүнчлэн олон улсын харилцааны тухайн үеийн нөхцөл байдлын онцлогоос үүдэн дипломат ажиллагаа, түүний хэлбэр, хэрэгжилтэд цаашдаа ч өөрчлөлт орсоор байх хандлагатай байна. Дэлхийн олон улс орнууд, тэр дундаа олон улсын харилцаанд голлох үүрэгтэй, нөлөө бүхий олон гүрнүүд сүүлийн үед Олон нийтийн дипломат ажиллагааг чухалчлан үзэж, судлах нь эрчимжиж байна. Улс орнуудын харилцаанд болон дэлхийн улс төрд хатуу хүч, улс төрийн манипуляци буюу муу арга заль голлож байсан цаг нэгэнт үеэ өнгөрөөж, зөөлөн хүч, ухаалаг дипломат ажиллагаа буюу зөв мэргэн арга ухаан давамгайлах боломжтой гэж итгэх үзлийг хүмүүст төлөвшүүлэх нь олон нийтийн дипломат ажиллагааны нэг зорилго юм. Учир нь энэ дипломат ажиллагаа нь их энгийн явагдах агаад тэвчээртэй сонсох чадвар, дотносох сэтгэл, итгэлцэл, чин сэтгэлийн яриа хөөрөө, нөхөрлөлөөр дамжин үр дүнтэй хэрэгждэг учраас ирээдүйн ач холбогдол нь их юм. Олон түмэн манипуляцид өртөх магадлал өндөр байгаа Монголын өнөөгийн нөхцөл байдалд Олон нийтийн дипломат ажиллагааг гүнзгийрүүлэн судлах нь цаашид манипуляцыг хязгаарлах, популистуудын хийрхлээс ангид улс төрийн соёлыг олон түмэнд төлөвшүүлэх, популист улс төрчдийн нөлөөнд хэт автахгүй байх, улмаар ардчилалын үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд дөхөм болох юм.

Тиймээс улс орон гадаад бодлогоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд сайн үр дүн, жинхэнэ мэдлэг туршлага, халуун дотно харилцааг олны дунд бий болгодог олон нийтийн дипломат ажиллагааг дэмжиж, түүний эерэг нөлөө, ач холбогдолд итгэж, иргэд, олон нийтийн оролцоо, нөлөөг дэмжиж идэвхжүүлэх нь аливаа улсын олон улсын тавцан дахь нэр хүнд, байр суурь, эрх ашигт эерэгээр нөлөөлөх учиртай юм. Иймд олны хүч оломгүй далай гэдгийг илтгэн харуулдаг олон нийтийн дипломат ажиллагааны талаарх судалгааг манай улс эрчимжүүлж, энэ дипломат ажиллагааг хэрэгжүүлэх нь уршигт үр дагаварт хүргэдэг улс төрийн манипуляцыг хязгаарлах бололцоог олгох юм.

НОМ ЗҮЙ

1. Ernest Satow, "Guide to diplomatic practice" .. 5th ed. London. New York. 1979
2. В. И. Попов. "Орчин үеийн дипломат ажиллагаа" (Онол практикийн асуудал).. УБ, 2007.
3. The Concise Oxford Dictionary of Politics. NY. 2009
4. Д. Цолмон, Д. Оюунсүрэн, С. Баясгалан, "Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс", УБ, 2009
5. Peu Ghosh, "International relations", New Delhi-110001, 2009
6. Nicholas J. Cull, "Public Diplomacy: Lessons from the Past", Los Angeles, 2009
7. J. C. Johari, "International Relations and Politics" (Theoretical Perspective in the Post-Cold War Era), New Delhi-110016, 2009